



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/01/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	12
3.5.3 Урьдчилгаа	12
3.5.4 Бараа материал	12
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	13
3.5.6 Үндсэн хөрөнгө	13
3.5.7 Өр төлбөр	14
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	21
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	21
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын суудал	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуушимод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/245
танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Бүрэн сум нь Монгол Улсын Засгийн газраас "Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн" өрнүүлж, цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралыг даван туулах, баялаг бүтээгчдээ дэмжих эрхэм зорилгыг хэрэгжүүлэхээр "Ногоон хөгжил баялаг бүтээгчдийг" дэмжих урианы жил болгон зарлаж ажилласан байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай "Баялаг бүтээгчдийг дэмжих" зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 90.04%-тай биелүүлж, "А" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн инженерийн шугам сүлжээний өргөтгөлд 138,043.6 мянган төгрөг, нийтийн ахуйн үйлчилгээний засварт 99,292.8 мянган төгрөг, сумын төвийн хур хог хаягдал цэгцлэхэд 75,411.5 мянган төгрөг, сумын төвийн худаг засвар ашиглалтын зардалд 5,903.4 мянган төгрөг, малын худагт 44,952.1 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

G/Архив/Албан бичиг 2023/ А4
19020466

Энэ нь Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны 10/84 тоот албан бичгийн дагуу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн 2,320,655.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 168,643.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,187,408.90	676,042.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	419,365.60	221,666.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	452,531.40	290,569.30
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	315,512.00	163,806.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,441,885.90	3,323,542.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,441,885.90	3,323,542.00
39200	Биет хөрөнгө		5,117,627.40	3,162,186.40
39300	Биет бус хөрөнгө	13	324,258.50	161,355.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,629,294.80	3,999,584.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,418.10	10,412.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	16,418.10	10,412.40
41300	Өглөг	17а, 17б	16,418.10	10,412.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,612,876.70	3,989,172.20
51	Засгийн газрын хувь оролцоо		6,612,876.70	3,989,172.20
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,236,198.20	634,260.20
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		2,236,198.20	634,260.20
51200	Хуримтлагдсан үр дүн		3,477,382.00	3,073,284.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		899,296.50	281,627.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,629,294.80	3,999,584.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,914,254.10	1,500,142.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО		266,914.40	289,581.90
110	Орлогын албан татвар		83,333.90	184,226.90
1100	Хувь хүний орлогын албан татвар		83,333.90	198,021.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0	-13,794.60
113	Хөрөнгийн албан татвар		1,552.00	48,209.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		182,028.60	57,145.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,208,541.40	344,358.40
120	Нийтлэг татварын бус орлого		1,208,541.40	344,358.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,438,798.30	866,202.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,440,543.00	1,425,116.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,440,543.00	933,729.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,522,162.00	891,637.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,481,787.60	312,175.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		198,037.70	39,819.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		178,592.40	192,162.80
2104	Хангамж, бараа материалын зардал		66,786.60	36,761.00
2105	Нормативт зардал		105,653.40	38,300.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,238.00	23,796.40
2107	Томиллолт, зочны зардал		5,249.60	3,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,180.50	24,878.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		469,636.20	220,602.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		918,381.00	42,091.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	491,387.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,473,711.10	75,026.60
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		74,125.40	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		161,161.60	2,490,757.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,386,674.90	-2,415,730.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,796,557.5	1,326,226.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	266,914.4	289,581.9
110	Орлогын албан татвар	83,333.9	184,226.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	83,333.9	198,021.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-13,794.6
113	Хөрөнгийн албан татвар	1,552.0	48,209.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	182,028.6	57,145.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,335.4	3,389.8
1181	Газрын төлбөр	169.7	7,845.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	178,523.5	45,910.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	243,320.2	170,039.0
120	Нийтлэг татварын бус орлого	243,320.2	170,039.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,286,322.9	866,605.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,195,654.8	797,727.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,195,654.8	797,727.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,258,383.5	719,013.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,462,976.6	311,280.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,687.6	39,808.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,697.8	192,162.8
2104	Хангамж, бараа материалын зардал	131,190.5	71,456.5
2105	Нормативт зардал	111,882.2	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,007.0	23,539.4
2107	Томилолт, зочны зардал	5,075.9	3,198.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,067.2	26,214.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,798.6	51,351.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	937,271.3	78,714.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	600,902.7	528,498.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	198,584.9	615,602.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	198,584.9	615,602.5
2200	Дотоод эх үүсвэрээр	198,584.9	615,602.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-198,584.9	-615,602.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-102,068.7	-110,595.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	102,068.7	110,595.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	300,249.1	-197,698.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	119,116.6	419,365.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	419,365.6	221,666.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,225,168.3	5,225,168.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,003.6	21,003.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,246,171.8	5,246,171.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-19,970.0	-19,970.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,386,674.9	1,386,674.9
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,612,876.7	6,612,876.7
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,612,876.7	6,612,876.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-207,973.8	-207,973.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,404,902.8	6,404,902.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-2,415,730.6	-2,415,730.6
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,989,172.2	3,989,172.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	хэтрэлт, хэмнэлт	хэрэгжилт ийн хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,600,988.1	1,376,224.0	224,764.10	86.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	718,222.4	650,026.5	68,195.93	90.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,092.9	635,897.0	68,195.93	90.3%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,051.1	309,386.4	21,664.75	93.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,161.4	39,353.6	4,807.76	89.1%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	226,479.6	192,162.8	34,316.79	84.8%
2104	Хангамж, бараа материалын зардал	23,751.2	23,742.4	8.80	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,500.0	23,539.4	960.56	96.1%
2107	Томилолт, зочны зардал	3,198.6	3,198.6	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,129.0	25,706.9	6,422.12	80.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,822.0	18,806.8	15.16	99.9%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,129.5	14,129.5	0.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,129.5	14,129.5	0.00	100.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	652,765.7	615,602.5	37,163.17	94.3%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	230,000.0	110,595.0	119,405.00	48.1%
230001	Эргэж төлөгдөх зээл	230,000.0	110,595.0	119,405.00	48.1%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,600,988.1	1,331,138.6	269,849.50	83.1%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	339,644.7	339,644.7	0.00	100.0%
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	339,644.7	339,644.7	0.00	100.0%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	778,222.4	892,738.6	-114,516.21	114.7%
320001	Орон нутгийн төсвөөс	778,222.4	892,738.6	-114,516.21	114.7%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	483,121.0	98,755.3	384,365.71	20.4%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	230,000.0	98,755.3	131,244.71	42.9%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	253,121.0	0.0	253,121.00	0.0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.0	139,698.0	-139,698.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.0	119,581.4	-119,581.37	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	120	119	1.00	
620001	Удирдах ажилтан	8	8	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	81	78	3.00	
620003	Үйлчлэх ажилтан	30	29	1.00	
620004	Гэрээт ажилтан	1	4	-3.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	303,218.55	53,178.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,218.55	53,178.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	233,414.40	17,911.84
2104	Хангамж, бараа материалын зардал	12,769.80	1,166.40
2105	Нормативт зардал	48,730.64	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,609.90	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,757.88	400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,546.18	16,345.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,804.15	35,266.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,604.50	7,760.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,199.65	27,506.37
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	310,022.57	46,374.19
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	310,022.57	46,374.19
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	6,804.02	-6,804.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,804.02
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	6,804.02	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга нь тайлант онд сумын хогийн цэгийн 12 га талбайд тархсан хур хог хаягдлыг 3 га болгон цэвэрлэж отполь үүсгэн хашаажуулан нарны зайн гэрэлтүүлэг, 360 градус эргэдэг камер зэргийг байршуулсан байна. Сумын төвийн малчдад зориулж өвөл, хаврын улиралд ихээр тулгардаг асуудал болох малын усны цахим худгийг шинээр гаргасан байна. Дулаан цэвэр усны инженерийн шугам сүлжээний өргөтгөл 220 метр газар 5 худаг хийж тус ажлын хүрээнд 12 айл өрх шинээр дулаанд холбогдсон байна. Ахуйн үйлчилгээний төвийг их засварт оруулж орчин үеийн шаардлага хангасан халуун ус, хувцас угаалга, үсчин, нийтийн бие засах газар, гуталчин, хүнсний цехийн зориулалтай ашиглаж байна. Мөн сургуулийн 160 хүүхдийн дотуур байр шинээр барих ажил эхэлсэн байна.

Тус байгууллага нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцаас 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний зураг” хийлгэсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Баялаг бүтээгчдийг дэмжих” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 32 хэрэгжүүлэх арга хэмжээ батлуулж, 29 арга хэмжээг хэрэгжүүлж, 3 арга хэмжээг тасалдуулан 90,04%-тай биелүүлж, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын төсөвт байгууллагууд удирдах 8, гүйцэтгэх 81, үйлчилгээний 30, нийт 120 орон тоотой баталж, гүйцэтгэлээр 119 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бүрэн сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд Бүрэн сумын шилэн дансны хөтлөлт, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нэгдсэн дүнгээр

90% буюу шаардлага “бүрэн хангасан” гэсэн дүгнэлт өгч, ОНХС-ийн 2021 оны санхүүгийн баримтад хяналт шалгалтаар 80% буюу шаардлага “дунд хангасан” гэсэн дүгнэлт өгсөн байна.

Бүрэн сумын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нэгтгэсэн тайланд хамрагдаж байгаа 10 байгууллагаас ЗДТГ, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг 3 байгууллага аудитын өөрчлөлтгүй дүгнэлт, эрүүл мэндийн төв хязгаарлалттай дүгнэлт авч, ИТХ, соёлын төв, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, эргэлтийн эмийн сан, орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сан нь түүвэрт хамрагдсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,623,704.5 мянган төгрөгөөр буюу 39,7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	419,365.6	221,666.8	-197,698.8
Авлага	452,531.4	290,569.3	-161,962.1
Бараа материал	315,512.0	163,806.5	-151,705.5
Үндсэн хөрөнгө	5,441,885.9	3,323,542.0	-2,118,343.9
Нийт хөрөнгө	6,629,294.8	3,999,584.6	-2,629,710.2
Өр төлбөр	16,418.1	10,412.4	-6,005.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,612,876.7	3,989,172.2	-2,623,704.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,629,294.8	3,999,584.6	-2,629,710.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 221,666.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 197,698.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь эрүүл мэндийн төвийн 36,122.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг шилжүүлж, Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 97,413.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 170,889.3 мянган төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 88,807.1 мянган төгрөг болж 11,839.7 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 290,569.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 161,962.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн

172.552.0 мянган төгрөгийн, сургуулийн 4,493.7 мянган төгрөгийн, цэцэрлэгийн 2,577.4 мянган төгрөгийн авлагыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 163,806.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,705.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 168,643.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,323,542.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,118,343.9 мянган төгрөгөөр буурсан нь ЗДТГ-т 111,496.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 104,920.6 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр орлого авсан боловч үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,320,655.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж тайлагнасан нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,412.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,005.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 6,493.0 мянган төгрөгийн, соёлын төвийн 1,278.6 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэн нь голлож нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,989,172.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,623,704.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, өглөг, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,415,730.6 мянган төгрөг болсон нь нөлөөлсөн байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 221,666.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 197,698.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	419,365.6	221,666.8	-197,698.8
Төгрөг	419,365.6	221,666.8	-197,698.8
Төрийн сангийн харилцах	412,144.7	221,020.7	-191,124.0
Арилжааны банк дахь харилцах	416.9	646.1	229.2
Нэмэлт санхүүжилтийн харилцах	6,804.0	0.0	-6,804.0
Дүн	419,365.6	221,666.8	-197,698.8

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 221.020.7 мянган төгрөгийн 44,1 хувь буюу 97,413.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 13,9 хувь буюу 30,774.3 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 40,2 хувь буюу 88,807.1 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 1,8 хувь буюу 4,026.0 мянган төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 646.1 мянган төгрөг арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 191,124.0 мянган төгрөгөөр буурсан нь Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өмнөх оноос 170,899.3 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 11,839.7 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Арилжааны банканд оны эхний үлдэгдэлд эмийн эргэлтийн сангийн харилцахын үлдэгдэл 229.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр өссөн нөлөөллийг үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт: Эмийн эргэлтийн сан арилжааны банк дахь харилцахын оны эхний үлдэгдэл 416.9 мянган төгрөг, эм бараа борлуулалтын орлого 47,221.4 мянган төгрөг, урьд оны авлагаас 2,150.2 мянган төгрөг харилцах дансанд төвлөрүүлсэн. Эм, бараа материал худалдан авахад 46,072.5 мянган төгрөг, бусад зардалд 3,069.9 мянган төгрөг нийт 46,142.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, харилцах дансны үлдэгдэл 646.1 мянган төгрөг тохирч байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 195,239.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 70,784.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	7,071.10	0	-7,071.10
Зээлийн хүүгийн авлага	13,958.00	17,456.40	3,498.40
Төлбөртэй үйлчилгээний авлага	172,522.00		-172,522.00
Байгууллагаас авах авлага	20,230.90	10,833.00	-9,397.90
Хувь хүмүүсээс авах авлага	238,719.40	262,279.90	23,560.50
Дүн	452,531.40	290,569.30	-161,932.10

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 290,569.3 мянган төгрөгийн 90,3 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 3,7 хувийг байгууллагаас авах авлага, 6,0 хувийг зээлийн хүүгийн авлага эзэлж байна. Нийт авлагын дансны үлдэгдлийн 94,7 хувь буюу 275,225.0 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн, 3,7 хувь буюу 10,800.0 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 1,5 хувь буюу 4,343.9 мянган төгрөг нь эргэлтийн эмийн сангийн, .1 хувь буюу 200.5 мянган төгрөг нь ЗДТГ-ын авлага эзэлж байна.

Авлага дансны үлдэгдэл оны эхнээс 161.932.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих сумын Эрүүл мэндийн төвийн 172,522.0 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагыг, сургуулийн 4,493.7 мянган төгрөгийн, цэцэрлэгийн 2,577.4 мянган төгрөгийн авлагыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт: Бүрэн сумын ИТХ нь нийгмийн даатгалын шимтгэлийн 61.2 мянган төгрөгийн авлагыг тайлагнаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 163,806.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,705.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	170,863.40	93,875.20	-76,988.20
Тусгай зориулалттай материал	34,227.70	5,674.20	-28,553.50
Эм боох материал	135,755.50	88,201.00	-47,554.50
Бэлэн бүтээгдэхүүн	880.2	0	-880.20
Хангамжийн материал	144,648.70	66,231.30	-78,417.40
Бичиг хэргийн материал	5,648.50	2,970.90	-2,677.60
Аж ахуйн материал	64,186.40	16,864.00	-47,322.40
Сэлбэг хэрэгсэл			0.00
Түлш, шатах тослох материал	1,350.00		-1,350.00
Хүнсний материал	4,624.00		-4,624.00
Бусад хангамжийн материал	68,839.80	46,396.40	-22,443.40
Мал амьтад		3,700.00	3,700.00
Дүн	315,512.10	163,806.50	-151,705.60

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 163,806.5 мянган төгрөгийн 40,6 хувийг ЗДТГ, 53,8 хувийг эмийн эргэлтийн сан, 2,1 хувийг ИТХ-ын, 3,5 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 163,806.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,705.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 168,643.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой бөгөөд тайлант онд ЗДТГ-ын бараа материалын үлдэгдэл 10,045.7 мянган төгрөгөөр, ИТХ-ын бараа материал 128.2 мянган төгрөгөөр, эргэлтийн эмийн сангийн бараа материал 6,764.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,323,542.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,118,343.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,117,627.4	3,162,186.4	-1,955,440.9
Барилга, байгууламж, орон сууц	4,441,992.3	2,760,867.0	-1,681,125.3
Авто-тээврийн хэрэгсэл	136,901.4	71,140.9	-65,760.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	294,010.5	54,396.2	-239,614.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	98,214.6	54,233.5	-43,981.1
Зам гүүрний байгууламж	80.0	43.1	-36.9
Түүх соёлын дурсгалт зүйл	24.0	24.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	113,141.5	221,481.8	108,340.2
Ном	33,263.2		-33,263.2
Биет бус хөрөнгө	324,258.5	161,355.6	-162,903.0
Программ хангамж	461.1	225.0	-236.1
Бусад биет бус хөрөнгө	323,797.4	161,130.6	-162,666.9
Дүн	5,441,885.9	3,323,542.0	-2,118,343.9

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,7 хувь буюу 3,313,874.2 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,3 хувь буюу 9,667.8 мянган төгрөгийг ИТХ-ын хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,323,542.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,118,343.9 мянган төгрөгөөр буурсан нь ЗДТГ болон ИТХ-д 111,496.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 104,920.6 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр орлого авсан боловч үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,320,655.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж тайлагнасан нь нөлөөлсөн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний “Сумын 2022 оны үндсэн хөрөнгө данс бүртгэлд авах тухай” 04 дүгээр тогтоолоор төсвийн шилжих үлдэгдэл, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн 627,508.2 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авч, сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны хуралдааны “Хөрөнгө шийдвэрлүүлэх тухай” 06 дугаар тогтоолоор 1151 нэр төрлийн 26,046.9 мянган төгрөгийн хөрөнгийг актлаж устгахаар шийдвэрлэснийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор хэрэгжүүлсэн байна.

Сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд төсвийн шилжих үлдэгдлээр 23,390.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 29,893.8 мянган төгрөгийн үерийн далангийн зураг, 10,520.0 мянган төгрөгийн нарны зайн гэрэлтүүлэг, 19,000.0 мянган төгрөгийн гэрэлт гудамж, 28,692.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил компьютер тоног төхөөрөмж, нийт 111,496.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ОНХС-ийн хөрөнгөөр 135,497.2 мянган төгрөгийн дулааны шугам сүлжээг сайжруулалтаар, 75,411.5 мянган төгрөгийн хогийн цэг, 45,000.0 мянган төгрөгийн малын худаг, цагдаагийн газраас 4,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл зэрэг нийт 104,920.6

мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр орлого авч, сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны хуралдааны 06 дугаар тогтоолоор 9,686.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж устгасан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 10,412.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,005.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өр	2,712.1	0	-2,712.1
Байгууллагад төлөх өр	13,706.0	10,412.4	-3,293.6
Дүн	16,418.1	10,412.4	-6,005.7

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 10,412.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,005.7 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн 6,493.0 мянган төгрөгийн, соёлын төвийн 1,278.6 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлж, ЗДТГ-ын өглөг 2,544.1 мянган төгрөгөөр буурч, эргэлтийн эмийн сангийн өглөг 4,310.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нөлөөллийг үзүүлсэн байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдлийн 95,9 хувь буюу 9,986.5 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 4,1 хувь буюу 425.9 мянган төгрөг нь ЗДТГ-ын өглөг эзэлж байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,989,172.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,623,704.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,236,198.2	634,260.2	-1,601,938.0
Хуримтлагдсан үр дүн	3,477,382.0	3,073,284.8	-404,097.2
Өмнөх үеийн үр дүн	2,090,707.1	5,489,015.4	3,398,308.3
Тайлант үеийн үр дүн	1,386,674.9	-2,415,730.6	-3,802,405.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	899,296.5	281,627.2	-617,669.3
Дүн	6,612,876.7	3,989,172.0	-2,623,704.7

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 2,623,704.7 мянган төгрөгөөр буурсан нь засгийн газрын оруулсан капитал 1,601,938.0 мянган төгрөгөөр буурч, хөрөнгийн дахин үнэлгээ 617,669.3 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 3,398,308.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 3,802,405.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 3,989,172.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,623,704.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, өглөг, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн (2,415,730.6) мянган төгрөг болсон нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Бүрэн сумын төсвийн байгууллагуудын төсвийн төсөлд 925,264.4 мянган төгрөгийн орлого, зардлын саналыг төлөвлөж төсвийн ерөнхийлөн захирагчид 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн А/45 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 03 дугаар тогтоолоор тусгай санхүүжилтийн байгууллагуудын төсвийг салбар тус бүрийн төсвийн ерөнхийлөн захирагчаас санхүүжүүлэхээр шийдвэр гарсны дагуу төлөвлөгөөг 96,166.5 мянган төгрөгөөр бууруулж, 829,097.9 мянган төгрөгийн төсөв баталж ирүүлсэн байна.

Бүрэн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 256,012.1 мянган төгрөг, татварын бус орлогыг 58,570.0 мянган төгрөг, татварын буцаан олголтыг 16,244.5 мянган төгрөг, нийт татварын орлогыг 297,636.1 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,419,863.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Мөн өдрийн “Сум хөгжүүлэх сангийн 2022 оны төсөв, үйл ажиллагааны зардлыг батлах тухай” 06 дугаар тогтоолоор сум хөгжүүлэх сангийн төсвийг 230,000.0 мянган төгрөгөөр тогтоож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 297,636.1 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах нийт зарлагыг 1,370,988.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 297,636.1 мянган төгрөгөөр, нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 48,875.5 мянган төгрөгөөр бууруулж, 908,222.4 мянган төгрөгөөр, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварыг 62,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 252,000.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 400,765.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,370,988.1 мянган төгрөгөөр сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Сумын 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 05 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 33 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 297,636.1 мянган төгрөг, орон нутгийн төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 480,586.2 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 339,644.7 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 1,121.1 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 252,000.0 мянган төгрөг, нийт 1,370,988.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Бүрэн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Сум хөгжүүлэх сангийн 2022 оны төсөв, үйл ажиллагааны зардлыг батлах тухай” 06 дугаар тогтоолоор сум хөгжүүлэх сангийн төсвийг 230,000.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,376.2 мянган төгрөг буюу 86,0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 68,195.9 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангаас олгогдоогүй зээл 119,405.0 мянган төгрөг, ОНХС-аас худалдан авах ажиллагааны журмын дагуу зарлагдсан тендерт оролцогч байхгүйгээс 37,163.2 мянган төгрөгийн хөрөнгийн зардал зарцуулагдаагүй зэргээс шалтгаалсан байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	72,202.5	68,028.6	-4,173.9	94.2%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	389,480.0	365,893.6	-23,586.4	93.9%
3	Соёл урлагийн үйлчилгээ	17,083.4	14,879.1	-2,204.3	87.1%

4	ЭМТ-ийн үйлчилгээ	25,752.3	23,214.7	-2,537.6	90.1%
5	ЕБС-үйлчилгээ	164,763.5	129,398.7	-35,364.8	78.5%
6	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	48,940.7	48,611.8	-328.9	99.3%
7	Хөрөнгө оруулалтын зардал	252,000.0	242,574.8	-9,425.2	96.3%
8	Орон нутгийн хөгжлийн сан	400,765.7	373,027.7	-27,738.0	93.1%
9	Хоршоо хөгжүүлэх сан	230,000.0	110,595.0	-119,405.0	48.1%
	Сумын дүн	1,600,988.1	1,376,224.0	-224,764.1	86.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 45,974.2 мянган төгрөг, ИТХ 400.0 мянган төгрөг, эрүүл мэндийн төв 6,804.0 мянган төгрөг, нийт 63,178.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	100%	72,202.5	68,028.6
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	90.04 %	389,480.0	365,893.6
3	Соёл урлагийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	17,083.4	14,879.1
4	Ерөнхий боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	78.5%	164,763.5	129,398.7
5	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	48,940.7	48,611.8

6	ЭМТ-ийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	25,752.3	23,214.7
7	Хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр арга хэмжээ	2022 он	хөрөнгийн чанар байдал сайжирч шинэчлэгдэнэ.	96.3%	252,000.0	242,574.8
8	Орон нутгийн хөгжлийн сан	2022 он	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, Нийтийн ахуйн үйлчилгээ, худаг засвар, хур хог хаягдал, малын худаг, малын ээмэгжүүлэлт	93.1%	400,765.70	373,027.70
9	Хоршоо хөгжүүлэх сан	2022 он	Эргэж төлөгдөх зээл олголт хийх	48.1%	230,000.00	110,595.00
	Нийт зарлагын дүн	2022 он	Хэрэгжилт хангагдана	86.0%	1,600,988.10	1,376,224.01

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд орон нутгийн хөгжлийн сангаас худалдан авах ажиллагааны журмын дагуу зарлагдсан тендерт оролцогч байхгүйгээс 37,163.2 мянган төгрөгийн хөрөнгийн зардал зарцуулагдаагүй байна. Энэ нь малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө биелээгүй бөгөөд 140 өрхийн 11,295.8 мянган төгрөгийн дутуу төлөлтийн үлдэгдэл байна.

Ерөнхий боловсролын сургуулийн шинэ барилга ашиглалтад ороогүйгээс түлш халаалтын зардлаас 34,316.8 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүллээ.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 01/83 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Бүрэн сумын

Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 1,370,988.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 20,564.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,423.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн жилийн хүрээнд орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 26,472.4 мянган төгрөг, сургуулийн шинэ барилга ашиглалтад ороогүйгээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 34,316.8 мянган төгрөг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 174 мэдээллээс 27 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй төлөвтэй байна. Тендер шалгаруулсан, худалдан авах ажиллагаатай холбоотой 1,662,283.4 мянган төгрөгийн 33 мэдээлэл, 29,916.9 мянган төгрөгийн 67 шийдвэр байршуулсан бөгөөд нэгдсэн тайланд хамрагдагч байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотойгоор ЗДТГ, хоршоо хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, эмийн эргэлтийн сангийн нийт 488,264.9 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.3-д харуулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.3-д харуулав.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдэж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр болон дүнгээр нь биелүүлэх талаар 1 зөвлөмж өгөгдсөн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөний хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 21-ний 01/146 тоотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, хэрэгжилтийг fas.audit.mn системд бүрэн хэрэгжсэнээр шивсэн байна. Гэвч татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр болон дүнгээр нь биелүүлээгүй зөрчил давтан илэрсэн байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	28,360.3	2	28,360.3	100
Нийт дүн	2	28,360.3	2	28,360.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудалгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

- Аудитаар нэгтгэсэн тайланд харьяа 4 байгууллагын тайланд буруу тусган илэрхийлсэн 204,290.4 мянган төгрөгийн 4 алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулга хийгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн 6.1-д харуулав.

5.1 Төлбөрийн акт

Бүрэн сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 4,645.9 мянган төгрөгийн 1 зөрчил, ИТХ-ын 61.2 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

1.Нэмэлт санхүүжилтийн дансанд он дамнан зарцуулаагүй үлдэгдэл 4,645.9 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх” зарчимтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “ангилал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

2.ИТХ нь нийгмийн даатгалын шимтгэлийн 12 дугаар сарын тайланд илүү төлөлттэй гарсныг авлагаар тайлагнаагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар

зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн” зарчимтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос, үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

- Аудитаар Бүрэн сумын нэгтгэсэн тайлангийн 4,645.9 мянган төгрөгийн 1 зөрчил, ЗДТГ-ын 1,070.9 мянган төгрөгийн 2 зөрчил, ИТХ-ын 61.2 мянган төгрөгийн 1 зөрчил, нийт 5,778.0 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Төлбөрийн акт тогтоогдсон зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

5.2 Албан шаардлага

Тус байгууллага тайлант онд төсвийн орлогыг нийт дүнгээр 97,7 хувиар биелүүлж, 2,3 хувиар тасалсан бөгөөд улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлого, аймагт төвлөрүүлэх 1 нэр төрлийн, орон нутагт төвлөрүүлэх 9 нэр төрлийн орлогыг 82,598.7 мянган төгрөгөөр бүрдүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

- Аудитаар Бүрэн сумын нэгтгэсэн тайлангийн 82,598.7 мянган төгрөгийн 1 зөрчил, ЗДТГ-ын 4,122.0 мянган төгрөгийн 1 зөрчил, нийт 86,720.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Албан шаардлага өгөгдсөн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

5.3 Зөвлөмж

- Аудитаар Бүрэн сумын ЗДТГ-ын 15,300.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч, энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	15,356.3			1	15,356.3	1	15,356.3				
ИТХ	1	8,674.1			1	8,674.1	1	8,674.1				
ОНХС	1	179,958.4			1	179,958.4	1	179,958.4				
СХСан	1	301.6			1	301.6	1	301.6				
Дүн	4	204,290.4			4	204,290.4	4	204,290.4				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	2	87,244.6	1	4,645.9	1	82,598.70						
ЗДТГ	4	20,492.9	2	1,070.9	1	4,122.00	1	15,300.0				
ИТХ	1	61.2	1	61.2		-		-				
Дүн	7	107,798.7	4	5,778.0	2	86,720.7	1	15,300.0	0	0	0	0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эмийн эргэлтийн сан	1	17,100.0					1	17,100.0
СХС	1	134,083.6					1	134,083.6
ОНХС	1	337,081.3					1	337,081.3
ЗДТГ	1	0					1	0
Дүн	4	488,264.9					4	488,264.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	4	488,264.9					4	488,264.9